



Тогтвортой
хөгжлийн тайлан





АЛСЫН ХАРАА



Дэлхийн жишиг
Монголын банк

ЭРХЭМСЭГ
ОРШИХУЙ



Хөгжлийн
ГОЛОМТ

СТРАТЕГИ



Нээлттэй
банк



Агуулга

Удиртгал

7-9

- Удирдлагын амлалт

Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд

11-22

- Тогтвортой санхүүжилт
- Удирдлагын бүтэц, хяналт шинжилгээ
- Тогтвортой хөгжлийн бодлого
- Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ
- Чадавх бүрдүүлэлт
- Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалт

Байгаль орчны үзүүлэлтүүд

23-29

- Эрчим хүч
- Хүлэмжийн хийн ялгарал
- Уур амьсгалын өөрчлөлт
- Ус
- Хог хаягдал
- Биологийн олон янз байдал

Нийгмийн үзүүлэлтүүд



31-44

- Хүний нөөцийн хөгжил
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Эрх тэгш байдал
- Хүртээмжтэй орчин, оролцоо
- Нийгмийн хариуцлага, ил тод байдал
- Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага

Засаглалын үзүүлэлтүүд



45-50

- Компанийн засаглал
- Авлига, ёс зүй
- Комплаенс/Хууль дүрмийн мөрдөлт
- Оролцогч талуудын оролцоо

Салбарын нэмэлт үзүүлэлтүүд



51-59

- Санхүүгийн үйлчилгээ
- Нэмэлт үзүүлэлтүүд



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН

ТАЙЛАН 2022



Тогтвортой
бизнесийн үйл
ажиллагаа явуулах



Нийгэм, байгаль
орчны асуудлуудад
анхаарал тавих



Сэтгэл ханамжтай
ажлын байр
бий болгох

УДИРТГАЛ

Голомт банк нь стратегийн үндсэн чиглэлийн нэг болох Тогтвортой Хөгжлийг тасралтгүй дэмжин ажиллаж, түүнийхээ хүрээнд 2022 онд хийж, хэрэгжүүлсэн дотоод болон гадагшаа чиглэсэн ажлуудынхаа үр дүнг БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг баримтлан тайлагнав.

Та бүхэнд тайлан болон хэрэгжүүлсэн ажлуудтай холбоотой асуулт, санал зөвлөмж байвал sustainablefinance@golomtbank.com хаягаар бидэнтэй холбогдоорой. Мөн Голомт банкны Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй сүүлийн үеийн ажлуудтай www.golomtbank.com /Банкны тухай/ Тогтвортой хөгжил хэсгээс танилцах боломжтой.





Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, хамтран ажиллагсад та бүхэндээ 2022 оны Голомт банкны Тогтвортой хөгжлийн тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэлхий нийтээр анхаарал хандуулж, байгаль орчноо уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнөөс хамгаалахад хувь хүн, байгууллага бүрийн оролцоо чухал цаг үед бид амьдарч байна.

Голомт банк дэлхийн болон үндэсний хэмжээний

тогтвортой хөгжилд чиглэсэн зорилтуудад хувь нэмрээ оруулан хариуцлагатай бизнес эрхлэгч байхын зэрэгцээ байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн ажилладаг билээ.

Тухайлбал 2022 онд Голомт банк Жендерийн тэгш байдлын хороо болон Тогтвортой хөгжлийн хороодын үйл ажиллагааг идэвхжүүлсэн, бүтэц зохион байгуулалтад шинэчлэл хийн Тогтвортой санхүүжилтийн хэлтсийг шинээр байгуулж байгууллагынхаа тогтвортой хөгжлийн засаглалыг бэхжүүллээ.

Байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэлийн удирдлагын хүрээнд Голомт Банк нийт 667 бизнесийн зээл олгосны 71 хувьд нь БОН-ийн эрсдэлийн үнэлгээ хийсэн. Бид бизнесийн багцынхаа хүлэмжийн хийн ялгарал болон усны нөлөөллийг хэрхэн хэмжих талаар суралцаж, аргачлалыг тодорхойлон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийж анхаарал хандуулах шаардлагатай салбар, чиглэлийг тодорхойлов.

Удирдлагын амлалт

Монгол Улсын Ногоон Таксономийн ангиллаар Голомт банкны 2022 оны ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн багцын 2.6 хувьтай тэнцэж байна. Бид бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан харилцагчдынхаа ногоон тогтвортой төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, хамтран ажиллах тал дээр ихээхэн анхаарал хандуулж үйл ажиллагаандаа тусгадаг. Голомт банк өдөр тутмын дотоод үйл ажиллагаандаа

сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын тогтвортой менежментийг бүрдүүлэн ажиллахын зэрэгцээ ажилтнуудын тогтвортой хөгжлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор нийт 8702 хүн/цагийн тогтвортой санхүүжилт, байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ чиглэлээр сургалт зохион байгууллаа. Өнөөдрийг хүртэл бидэнтэй хамтран тогтвортой хөгжилд хувь нэмрээ


оруулж буй харилцагчид, хамтран ажиллагсад, нийт ажилтнууддаа талархал илэрхийлье.

Цаашид хамтдаа Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын цар хүрээгээ нэмэгдүүлж гаргасан ахиж дэвшил хийж хэрэгжүүлсэн бүхнээ ил тодоор тайлагнасаар байх болно.

Хүндэтгэсэн,



Гүйцэтгэх Захирал
Норихико Като





Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд






Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд

Тогтвортой санхүүжилт

2022 онд нийт 667 орчим бизнесийн зээл олгосноос



- 71% байгаль орчин, нийгмийн эрсдэлийн иж бүрэн үнэлгээ хийсэн байна.
- 29% Энгийн


Голомт банк 2022 онд “Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээний дотоод журам”-ыг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд БОН-ийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц бус өндөр эрсдэлийг тодорхойлох, эдийн засгийн 400 гаруй дэд салбарын тусгайлсан суурь үнэлгээний загвар, ногоон зээлийн үнэлгээ хийх загварчлал зэрэгт журмын сайжруулалтуудыг хийн БОН-ийн эрсдэлийн үнэлгээнд онцгой анхаарал хандуулан ажиллалаа.

Мөн “Partnership for Carbon Accounting Financials” хүлэмжийн хийн ялгарлыг

тооцоолох олон улсын стандартын байгууллагад гишүүнээр элсэн тус аргачлалыг зээлийн үнэлгээндээ тусгаж байна. Тайлант онд нүүрсхүчлийн хий ихээр ялгаруулагч салбаруудыг тодорхойлж, хийн ялгарлыг тооцоолох аргачлалыг нэвтрүүлсэн төдийгүй эдгээр салбарын зээл тус бүр дээр хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолдог боллоо. Ингэснээр харилцагчдынхаа үйл ажиллагааны явцад ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга замыг тодорхойлон хамтран ажиллах боломж бүрдлээ.

Голомт банк нь тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд ногоон зээлийн багцын хэмжээг өсгөх, гадны тогтвортой болон ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийн талаарх ажилтнууд, харилцагчдын ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг олон зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтынхоо хүрээнд 2022 онд Тогтвортой, Ногоон бизнесийн зээл, Олон улсын EDGE стандартад суурилсан ногоон амины орон сууцны зээл, эко-автомашины зээлийн бүтээгдэхүүнүүдийг тус тус зах зээлд шинээр нэвтрүүлэв.

2022 оны 4-р улирлын байдлаар Голомт банкны ногоон зээлийн багц нь 95.85 тэрбум төгрөг байна.




- 57% Ногоон барилга
- 21% Тогтвортой ХАА
- 21% Тогтвортой ус, хаягдал
- 1% Бусад



Тогтвортой байдлын удирдлагын
тогтолцооны үзүүлэлтүүд

Байгууллагын Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны бүтэц



**Тогтвортой байдлын удирдлагын
тогтолцооны үзүүлэлтүүд**



Тогтвортой хөгжлийн он цагийн ТОВЧОО



- Тогтвортой санхүүжилтийн бодлого батлав
- ТоС “Манлай банк 2016”- р шалгарав



- ОУСК-ийн Ногоон санхүүжилтийн чадавхи бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдав.
- Жендерийн тэгш байдлыг хангах бодлого батлав

2015-2016 ▶

2018 ▶



2017 ▶



2019 ▶

- НҮБ-ын "Хариуцлагатай банкны зарчмууд" ажлын хэсэгт нэгдэв



- НҮБ-н “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтдаа” амлалтанд нэгдэв
- НҮБ-ын чуулга уулзалтанд оролцож, “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-д албан ёсоор нэгдэв





Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд



- Жендерийн хороо байгуулагдав
- Тогтвортой Хөгжлийн бодлогоо шинэчлэв
- Монголбанкнаас “Онцлох ТоС банк”-р шалгаруулав
- БОН эрсдлийн үнэлгээг сайжруулав



- Тогтвортой Санхүүжилтийн хэлтэс байгуулагдав
- Ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд гаргав
- “Тогтвортой хөгжлийн тайлан 2021” гаргав
- Хариуцлагатай Банкны хэрэгжилтийн тайлан 2021 гаргав
- “Онцлох ТоС Банк 2022”- р шалгарав

2020 ▶

2022 ▶



2021 ▶

- ТоС “Манлай банк 2021”-р шалгарав
- Тогтвортой хөгжлийн хороо байгуулав
- “Тогтвортой хөгжлийн тайлан 2020” гаргав
- “Тогтвортой хөгжлийн стратеги 2022-2025” батлагдав
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлд манлайлан ажиллаж эхлэв





Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд

Тогтвортой хөгжлийн бодлого

Тогтвортой хөгжлийн бодлого

Голомт банк анх 2015 оноос “Тогтвортой санхүүжилтийн бодлого” батлан хэрэгжүүлж, 2019 онд “Тогтвортой Хөгжлийн Бодлого” болгон шинэчилсэн бөгөөд байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлыг банкны дотоод болон гадаад үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсээр байна.

Бид НҮБ-ын Байгаль орчны санхүүгийн санаачилгаас гаргасан “Хариуцлагатай Банкны зарчмууд”-ийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа уялдуулан байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлыг эрхэмлэдэг. Банк дотоод үйл ажиллагаа,

зээлийн үйл ажиллагаа, маркетинг, сургалт хөгжил болон хүний нөөцийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн хариуцлагатай байдал, эрсдэлийг тооцох талаар тогтвортой хөгжлийн бодлогодоо тусган ажиллаж байна.

Тогтвортой Хөгжлийн Хороо

2022 онд удирдлагын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн №27 дугаар шийдвэрийн дагуу Голомт Банкны Тогтвортой Хөгжлийн Хороо байгуулагдаж банкны тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилтийг хянан, удирдаж улирал бүр

тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн дотоод болон гадаад асуудлаар хуралдан үйл ажиллагаагаа явуулж байна. Тус хороо нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт, Парисын хэлэлцээрийн дагуу стратегийн уялдааг хангах, хариуцлагатай банкны зарчмын хэрэгжилтийг хянах,

банкны хяналт тайлагналыг сайжруулах зэрэгт анхааран хороонд орсон асуудлуудыг шийдвэрлэдэг бөгөөд Гүйцэтгэх захирал удирдаж, Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нарийн бичгээр ажиллаж байна.



Жендерийн Хороо

“Жендерийн тэгш байдлын хороо” нь 2021 онд байгуулагдсан ба жендерийн тэгш байдлыг дотооддоо ханган ажиллахаас гадна харилцагчдынхаа жендер, түүнийг дагасан эдийн засгийн хөгжлийн асуудлыг анхааран ажилласаар ирсэн. Иймд Голомт банкны зүгээс эмэгтэйчүүдэд санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, ахисан түвшинд хүргэж, тэднийг хийж чадах зүйлсээ бизнес болгон ашиг орлого олох, санхүүгийн дэмжлэг туслалцаа хүргэх, жендерийн тэгш байдлыг ханган эмэгтэйчүүдийн дуу хоолойг олон нийтэд хүргэх, нийгмийн сайн сайхны төлөө чиглэсэн

үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлэх зорилготойгоор Жендерийн тэгш байдлын хороо нь удирдлагын багийн гишүүдээс бүрдсэн бөгөөд улирал бүр хорооны хурлаа зохион байгуулан ажиллаж байна. Голомт Банкны Тогтвортой Хөгжлийн Стратегийн чиглэлд жендерийн тэгш байдлыг хангах зорилго багтсан бөгөөд Эмэгтэй Бизнес эрхлэгчдэд зориулсан бүтээгдэхүүний багцыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2022 оны 12-р сарын 21-ний өдрийн №21/03 тоот хорооны хурлын шийдвэрээр хорооны нарийн бичигт өөрчлөлт оруулан тогтвортой хөгжлийн

хэлтэс томилогдсон. Мөн стратегийн хүрээнд банк жендерийн мэдрэмжтэй банк болох зорилт тавин холбогдох судалгаа, бодлогын хөгжүүлэлт, дотоод сургалт зэргийг 2022 онд төлөвлөн 2023 оноос эхлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд банкны Жендерийн тэгш байдлын хороо нь хуралдан жендерийн үйл ажиллагааны хүрээнд чиглэл өгч, дотоод хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.



Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд

Тогтвортой Санхүүжилтийн хэлтсийн тухай товч

Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нь банкны Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги болон түүний хэрэгжилт, тайлагналд хяналт, шаардлага тавин ажиллахын зэрэгцээ тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэн “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг нийт банкны хэмжээнд таниулах, хэрэгжилтийг хангуулан ажиллах үүрэгтэй хэлтэс юм. Анх уг үүргийг Төслийн

санхүүжилтийн хэлтэс, түүний дараа Санхүүгийн хөгжлийн хэлтэс хариуцаж байсан бөгөөд Голомт банкны ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын саналаар тогтвортой хөгжлийг эрчимтэй дэмжин ажиллах зорилгоор 2021 онд “Тогтвортой санхүүжилтийн хэлтэс” -болгон шинэчилж байгуулсан.

Тус хэлтэс нь 2021 онд Голомт банкны “Тогтвортой хөгжлийн стратеги 2025”-ыг

боловсруулж “Тогтвортой хөгжлийн хороо”-гоор батлуулсан бөгөөд стратегийн хэрэгжилтэд хяналт, шаардлага тавин ажиллахын зэрэгцээ “Тогтвортой хөгжлийн хороо” болон “Жендерийн эрх тэгш байдлын хороо”-ны үйл ажиллагаа, хороодын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ

Голомт банк нь Тогтвортой хөгжлийг стратегийн голчлох чиглэлээрээ тодорхойлон НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилго, Үндэсний зорилтот хувь нэмэр, Хариуцлагатай банкны зарчмуудыг үйл ажиллагаандаа уялдуулан ажиллаж байна.

НҮБ-ын Байгаль орчин санхүүгийн санаачилгаас гаргасан банкны салбарын нөлөөллийн шинжилгээний аргачлалыг ашиглан

зээлийн багцынхаа байгаль орчинд нөлөөлж буй зэрэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлсон бөгөөд ус болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хамгийн өндөр хэмээн тодорхойлсон.

Ус болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг 2022 онд доорх гол ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Уур амьсгал:

- Барилгын материалын үйлдвэрлэл, эрчим хүч,

дулааны үйлдвэрлэл, уул уурхай, газрын тээвэр зэрэг салбаруудыг нүүрстөрөгчийн хий ялгаруулалт өндөртэй анхаарах салбаруудаар тодорхойлов.

- Нүүрстөрөгчийн ялгаруулалт өндөр салбаруудын Нүүрс төрөгчийн ялгаруулалт хэмжих аргачлалыг "ER tool" ашиглан боловсруулсан.
- 2022 оны 1-р сараас

**Тогтвортой байдлын удирдлагын
тогтолцооны үзүүлэлтүүд**

нүүрстөрөгчийн хий ялгаруулалт өндөртэй салбаруудын зээлийн багц дахь нүүрстөрөгчийн ялгарлыг хэмжиж суурь дата гаргасан. тодорхойлсон.

- Суурь датад үндэслэн тухайн салбарууд дахь нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах зорилтуудыг тогтоосон.
- БОНЭУ бодлогыг батлуулан зээлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
- CO2 ялгаруулалтыг бууруулах зорилттой уялдуулан ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлсэн.

Усны хүртээмж:

- Нийт зээлийн багцын ус их зарцуулдаг салбаруудаар хөдөө аж ахуй, алт олборлолт, төмөр ган, эрчим хүч үйлдвэрлэх, боловсруулах үйлдвэрийн салбаруудыг тодорхойлсон.
- 2022 оны 1-р сараас 2022 оны 12-р сар хүртэл зээлийн багцад жилийн усны хэрэглээг хэмжиж, суурь датаг гаргасан.
- Усны зарцуулалт өндөртэй багцын усны хэмжээг бууруулах зорилтуудыг тодорхойлсон
- Усны хэрэглээг бууруулах зорилттой уялдуулан ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилтуудыг тавьсан.

- Голомт банк Тогтвортой хөгжлийн бизнесийн стратеги-2023 дээрх нөлөөлөл өндөртэй салбаруудад анхаарал хандуулан ажиллах зорилт тавин ажиллаж байна. Бид ус болон уур амьсгалын нөлөөлөл өндөртэй салбаруудыг тодорхойлж, уг зээлийн багцын сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан нүүрстөрөгч, усны хэрэглээ өндөр үйлчлүүлэгчдээ дэмжин ажиллаж байна.

**Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд**

Ажилтнуудад зориулсан сургалтын тоо	Хүн цаг	Тоо	
Тогтвортой санхүүжилт	4074	1876	Хүн/Цаг
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ	181	181	Хүн/Цаг
Ногоон санхүүжилт	4010	1862	Хүн/Цаг
Бодлого, журмын тухай сургалт	181	181	Хүн/Цаг

Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалт

Principles for Responsible Banking
PROGRESS REPORT

**ТоС Холбооны Үнэлгээ**

“Монголын Тогтвортой санхүүгийн холбоо”(ТоС) нь 2016 оноос хойш нийт гишүүн банкны дунд ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээ хийж байна. 2022 оны ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээг Монгол банк, Олон улсын

Санхүүгийн Корпорацтай хамтран хийж гүйцэтгэхэд Голомт Банк А+ үнэлгээ авч ТоС-ийн хэрэгжилтийн үр дүнгээ ахиуллаа. Түүнчлэн Монгол Банкнаас жил бүр зохион байгуулдаг “Шилдэг ТоС Банк” уралдааны

хүрээнд Голомт Банк 2022 оны "Онцлох ТоС Банк"-аар шалгарсан бөгөөд Голомт Банкны зээлийн эрсдэлийн үнэлгээнд хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох шинэ санал санаачилгыг онцлов.




Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд

ҮНЭЛГЭЭ: **A+**

БАНКНЫ ТУХАЙ

Банкны нэр: Голомт Банк
 Харилцагчийн тоо: 1,040,426
 Ажилтны тоо: 1.957
 Салбарын тоо: 103

ҮНЭЛГЭЭНИЙ ТҮҮХ



ОНООНЫ КАРТ

Үнэлгээний хүрээ	Жин	Оноо	
		Авбал зохих	Авсан
1. Бодлого, стратеги	14.41%	31.5+0.5*	30.5
2. Бүтэц, зохион байгуулалт	9.01%	20	19
3. Эрсдэлийн удирдлага	26.58%	52+7*	51
4. Ногоон зээл болон бусад ногоон санхүүгийн бүтээгдэхүүн	22.97%	50+1*	39
5. Жендэр	6.31%	14	13.5
6. Сургалт, мэдээлэл	6.76%	15	15
7. Хяналт, тайлагнал	6.76%	15	11
8. Үлгэрлэн манлайлал	7.21%	10 +6*	14
НИЙТ	100%	222	193



Дараах QR холбоосоор тогтвортой хөгжлийн тайлангуудтай танилцана уу:





Байгаль орчны үзүүлэлтүүд





Байгаль орчны үзүүлэлтүүд

Эрчим хүч

Голомт банк нь дотоод эрчим хүчний хэрэглээний хэмнэлтдээ анхаарал хандуулан тогтвортой хөгжлийн бодлогыг баримтлан ажиллаж байна.

Эрчим хүчний хэмнэлтийг өмнөх онтой харьцуулахад 3.5 хувийн хэмнэлт гаргав. Голомт банк нь 3-р оффистоо нарны панел байрлуулан 2022 онд 5987 квт эрчим хүч

үйлдвэрлэж, тухайн оффисын хэрэглээний 3.7 хувийг хэмнэсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1: Банкны дотоод цахилгааны хэрэглээ

Цахилгаан, квт	2021	2022
3-р оффис	161,405.70	175,440.41
2-р оффис	149,293.00	174,298.05
Төв оффис	881,321.65	799,260.91
Парк	237,866.00	230,707.00
Нийт цахилгааны хэрэглээ	1,429,886.35	1,379,706.37

Тайлбар: 2-р оффис болон 3-р оффисуудын 2022 оны эрчим хүчний хэрэглээ нь өмнөх онтой харьцуулахад абсолют

байдлаар өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд Голомт банкны ажилчид Ковид -19 цар тахлын улмаас зайнаас

ажиллаж байсан ба 2022 онд хэвийн горимд шилжиж оффистоо ажиллаж байна.



Хүснэгт 2: Хүлэмжийн хийн ялгарал /Банкны дотоод хэрэглээ/

Банкны дотоод хэрэглээ Хүлэмжийн хийн ялгарал	2022	Хэмжих нэгж
Нийт эрчим хүчний хэрэглээ	1,379,706.00	Квт
Нийт дахивар хог хаягдлын хэмжээ		
Цаас	103.70	Киллограмм
Хуванцар	221.90	Киллограмм
Шил	1085.00	Ширхэг
Уут	221.90	Киллограмм
Лааз	35.10	Киллограмм
Дахин боловсруулах бусад шил	308.90	Киллограмм
Нийт усны хэрэглээ	7,349.00	м3
Нийт CO2 (Scope1)	31.90	Киллограмм
Нийт CO2 (Scope2)	5,475.96	тн

Байгаль орчны үзүүлэлтүүд

Уур амьсгалын өөрчлөлт

Нийт хүлэмжийн хийн ялгаралын 2.64 хувийг 2022 онд 140 мод тарьж оффсет хийсэн байна. Эрчим хүчний хэрэглээг бууруулж, байгаль орчинд ээлтэй эрчим хүч ашиглах зорилгоор цахилгаан бага зарцуулдаг лед гэрлийг оффисын хэрэглээндээ нэвтрүүлэх, дулааны алдагдлаа бууруулах ажлуудыг хийж байна.

Сайн дурын байгууллагуудаас зохион байгуулсан “Эх дэлхийгээ цэвэрлэх өдөр Сэлбэ гол” болон “Дахивар авах явуулын станц” (ДАЯС) аянд Голомт банкаас шуудай, бээлий, маск, цэвэр усны хангамж болон бусад шаардлагатай зүйлээр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа. Эдгээр аяны хүрээнд 120 байгууллагын 480 орчим хүн оролцсон. Сэлбэ гол

цэвэрлэх аяны хүрээнд 8,1тн хаягдал цуглуулсан бол ДАЯС арга хэмжээний хүрээнд 6тн хаягдал 4000 ширхэг дахин боловсруулах шил цуглуулсан.

Хаягдал батарей цуглуулах савыг оффис, салбарууддаа байршуулан, цуглуулсан батарейны аюулгүй байдлыг ханган хадгалж байна. Хамтран ажиллагч Төвшин Сайхан Мөнх НҮБТТ хамтран нэгдсэн устгал хийхээр ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй харилцагчдыг дэмжих зорилгоор засвар хийсэн салбарууддаа тэргэнцрийн стандарт налуу зам шинээр хийсэн.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нийт ажилтныг эрүүл мэндийн цогц

шинжилгээнд хамруулах, таатай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн цонхгүй салбаруудад цонх гаргах, зуны улиралд ажилчдын автобусаар үйлчлэх, ажилтнуудыг зун банкны зусланд гаргах зэрэг ажлуудыг хийсэн.

Голомт банкны ажилтнууд хандив цуглуулан “Хүүхдийн хөгжлийн төв” болон “Өнөр бүл” хүүхдийн асрамжийн төвд дэмжлэг үзүүлэх сайн дурын ажлыг "G-Volunteer", "G-student" клубууд хамтран зохион байгуулсан.



Ус

Голомт банк нь НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтийн санаачлагаас гаргасан "Банкны салбарт зориулсан Нөлөөллийн шинжилгээний аргачлал"-ыг ашиглан өөрсдийн зээлийн багцдаа уур амьсгалын нөлөөллийг тодорхойлох шинжилгээг 2021 онд хийсэн юм. Уг нөлөөллийн шинжилгээний үр дүнд банкны зээлийн багц нь ус болон уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж

байгааг батлан харуулсан бөгөөд 2030 он гэхэд уг сөрөг нөлөөллүүдийг бууруулах төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

Уур амьсгалын хүрээнд авч хэрэгжүүлэх зорилт: 2030 он гэхэд нөлөөлөл ихтэй зээлийн багцын нүүрсхүчлийн хэмжээг 30 хувиар бууруулна. 2050 он гэхэд Голомт банкны санхүүжүүлсэн, бууруулсан, зайлсхийх нийт цэвэр

нүүрстөрөгчийн хийг 50 хувиар бууруулна.

Усны хүрээнд авч хэрэгжүүлэх зорилт:

2030 он гэхэд усны зээлийн багцад эзлэх усны хэрэглээг 5 хувиар бууруулна. 2050 он гэхэд ус хэрэглээ өндөр салбарын зээлийн багцын усны хэрэглээг 10 хувиар бууруулна.

Хүснэгт 3: Банкны дотоод усны хэрэглээ

Ус, м3	2020	2021	2022
3-р оффис	1,624.00	1,026.00	1,368.00
2-р оффис	1,200.00	1,200.00	1,406.00
Төв оффис	1,886.00	1,092.00	2,018.00
Парк	2,182.00	1,579.00	2,557.00
Нийт усны хэрэглээ	6,892.00	4,897.00	7,349.00

Тайлбар: 2022 оны усны хэрэглээ өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. 2020 болон 2021 онд Голомт банкны ажилчид Ковид - 19 цар тахлын улмаас ээлжээр зайнаас ажиллаж байсан ба 2022 онд хэвийн горимд шилжиж оффисууддаа ажиллаж байна.



Байгаль орчны үзүүлэлтүүд

Хог хаягдал


Голомт банк дотоод хог хаягдлаа 2020 оноос эхлэн ангилан хаяж эхэлсэн бөгөөд 2022 онд аюултай хог хаягдлын нэг болох батарейг цуглуулах тусгай савыг оффисууддаа байршууллаа. Хог хаягдлын менежментээ

сайжруулж, дотооддоо байгаль орчинд сөрөг нөлөөтэй хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Төвшин сайхан мөнх НҮБТТ байгууллагатай хамтран оффисууд хог

хаягдлуудаас дахивар хаягдлыг ялган дахин боловсруулах станцад нийлүүлсэн. 2022 оны хувьд 0,8тн дахин боловсруулах нөөц, 985 ширхэг дахин ашиглах нөөц хуримтлуулсан байна.

Хүснэгт 4: Банкны дотоод дахивар хог хаягдалыг ангилан, хуримтлуулсан байдал

АНГИЛАЛ	2022	Хэмжих нэгж
Нийт дахивар хог хаягдлын хэмжээ		
Цаас	103.70	Киллограмм
Хуванцар	221.90	Киллограмм
Шил	1085,00	Ширхэг
Уут	221.90	Киллограмм
Лааз	35.10	Киллограмм
Дахин боловсруулах бусад шил	308.90	Киллограмм





Нийгмийн Үзүүлэлтүүд



3 ЗӨРХӨ МЭНДЭЙГ
ДЭВЖИХ



4 ЧАНДРАГ
БАЙДОРШЛИГ
ДЭВЖИХ



5 ХОНДЕРИЙН ОРХ
ТӨГӨ МЭНДЭЙГ
ХАИГАХ



8 ЗӨРИН ЗАСГИЙН
ОСВЛТ, ЗӨВСӨТӨН
МЭНДЭЙГ
ДЭВЖИХ



10 ТӨВӨН ГҮС
БАЙДЛЫГ
БУУРУУГАХ



12 ИХЭМЖИЛЭГЭЙН
ХӨРСӨГӨСӨГ
ДЭВЖИХ



13 ТУР ИЙЛГЭЭЛЭЙН
МОНГОЛЫН
УРЬДГАЙН
БАЙГАХ



17 ХӨГЖЛИЙН
ТӨВӨН
ТӨЛӨВӨЛӨГ
БЭЭЖИРЭХ



Нийгмийн үзүүлэлтүүд

СЭТГЭЛ ХАНАМЖТАЙ, ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР



Бид 2022 оны байдлаар нийт 2300 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагийн 70 хувийг нь 35-аас доош насны Y, Z үеийн залуус бүрдүүлж байна. Бизнесийн тасралтгүй ажиллагааг хангахад шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж, нийт 600 гаруй шинэ ажилтныг гэр бүлдээ нэгтгэв. Түүнчлэн банкны албан тушаалын карьерын

зураглалын дагуу дотоод шилжилт, хөдөлгөөн хийсэн ажилтнуудын 40 гаруй хувь нь албан тушаал дэвшсэн таатай үзүүлэлт гарсан. Голомт банк нь Жендерийн тэгш байдлыг хангах бодлого, Үл ялгаварлах бодлогын хүрээнд:
-Эрх тэгш байх
-Ялгаварлан гадуурхахгүй байх
-Мэдээллийн хүртээмжийг хангах

Хариуцлагатай байх тус тус зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг. Удирдах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүйсийн тэгш эрхийг хангах нь бидний баримталдаг гол зарчмуудын нэг бөгөөд удирдлагын багийн 23 хувийг чадварлаг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.

Хүснэгт 5: Банкны ажилчдын хүйсийн харьцаа

ҮЗҮҮЛЭЛТ	Хувь
Нийт эмэгтэй ажилтны тоо	65%
Нийт эрэгтэй ажилтны тоо	35%
· Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан	1.3%
· Нэг буюу түүнээс дээш жил ажиллаж буй ажилтан	81%
Удирдлагын баг /ТОП/	100%
· Эрэгтэй	23%
· Эмэгтэй	77%
Дунд түвшний удирдлагууд	100%
Эмэгтэй	46%
Эрэгтэй	54%



График 1: Банкны ажилтнуудын хүйсийн харьцаа




График 2: Ажилтнуудын ажилласан жил




График 3: Удирдлагын баг /ТОП/




График 4: Дунд түвшний удирдлагууд





График 5: Насны тархалт





Нийгмийн үзүүлэлтүүд

Голомт банк тогтвортой ажлын байрыг бий болгоход анхаарч ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, цалин хангамжийг сайжруулах, хөнгөлөлт урамшууллыг тухай бүрд тасралтгүй олгох замаар нийгмийн асуудлыг дэмжин ажилласаар ирсэн. 2022 онд нийт ажилтны цалинг дунджаар 20 хувиар нэмэгдүүлж цалингийн сүлжээг шинэчлэн батлав.

Эх орны хөгжлийн түүчээ, иргэн бүрийн аз жаргалтай амьдралын төлөө “Сайн сайхныг санхүүжүүлнэ” уриатайгаар үйл ажиллагаа явуулдаг Голомт банк нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Great place to work institute”-ээс “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг Монгол Улсын банк, санхүүгийн салбарт анхлан авлаа.

Ажилтнуудынхаа ажил амьдралын тэнцвэрийг хангах, амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэдний сэтгэл зүйн болон

биеийн эрүүл мэндэд анхаарахад чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагаануудыг нийт ажилтнуудын дунд нээлттэй зохион байгуулж амжилттай хэрэгжүүллээ.

“Адал явдалт, спорт явган аялал” арга хэмжээг 23 дахь жилдээ амжилттай зохион байгуулж 160 гаруй ажилтнуудыг хамрууллаа.

“Голомт лиг” сагсан бөмбөгийн арга хэмжээг 12 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Морин хуурын чуулга болон УДБЭТ-тай хамтран дэлхий хэмжээний шилдэг бүтээлүүдээс сорчлон нийт ажилтнууддаа цувралаар хүргэлээ.

Бүтээлч байдлыг нэмэгдүүлэх, үр бүтээлтэй, сэтгэл ханамжтай ажиллахад нь таатай нөлөө үзүүлэх, шинэ санал санаачилга, амжилтыг нь сайшаан алдаршуулах зорилгоор олон арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол улсын банкны салбарын хөгжил, эрх, тэгш өсөлт, банкны байгууллагыг

хөгжүүлэн бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан зүтгэлтэн, удирдах ажилтнаар 2022 онд Голомт банкны Гүйцэтгэх захирал тодорч Монголын банкны холбооны дээд шагнал “Хаш Эрдэнийн одон”-оор шагнагдлаа. Санхүүгийн зах зээл, банк, санхүүгийн системийг бэхжүүлэх, үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажилласан 210 гаруй ажилтнууд Монгол банкны шагналаар шагнагдлаа. Голомт банкны эрхэм зорилго, алсын хараа, бизнесийн өсөлт хөгжилд өөрийн мэдлэг, авьяас, үр чадвараа дайчилж, үнэтэй хувь нэм оруулан ажилласан 20 гаруй ажилтан “Голомт банкны шилдэг ажилтан”-аар шалгарч, 30 орчим ажилтан “Гадаад аяллын эрхийн бичиг”-ээр шагнагдлаа. 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулагдсан “Амжилт сайшаах” хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт 250 орчим ажилтныг “Бахархалт ажилтан”-аар өргөмжлөн алдаршууллаа.



АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид 2022 онд ажилтан төвтэй стратеги суралцан хөгжих, мэргэжлийн өндөр ёс зүйтэй байгууллагын соёлоо бэхжүүлэх зорилгын хүрээнд ажилтны замналыг сайжруулах, ажилтан бүрд ээлтэй, сурч хөгжих, өөрийгөө сорих боломжоор дүүрэн тогтолцоог бий болгох замаар банкны урт хугацааны тогтвортой




өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллалаа.

Тогтвортой хөгжлийн Чанартай боловсролыг дэмжих зорилгын хүрээнд:

- Ажилтан бүр тасралтгүй суралцан хөгжих, мэдлэгээ хуваалцах соёлыг бэхжүүлэх зорилготойгоор “Ажилтан-Та хөгжлийн голомт”, “Удирдах ажилтан бүр сургагч багш” уриан дор 2022 оны сургалт хөгжлийн олон шинэлэг үйл ажиллагааг

хэрэгжүүлсэн.

- Дижитал сургалтаас гадна micro learning, blended learning аргачлалуудыг сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн нийт сургалтын 30 орчим хувийг дижитал сургалт эзэлж байна. Ингэснээр ажилтнууд өөрийн боломжит цагийн хуваарьт тохируулан хүссэн газраасаа сургалт хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах боломж нэмэгдлээ.



Голомт банк жил бүр ажилтнуудаа мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, мэргэшүүлэх олон улсын болон дотоодын сургалт хөгжлийн хөтөлбөрүүдэд тогтмол хамруулдаг бөгөөд нийт сургалтын 30 гаруй хувийг мэргэжлийн ур чадварын сургалтууд эзэлж байна.

Гүрэн академитай хамтран Global growth institute-ийн World class manager vol.1, vol.2 сургалтуудыг оюуны өмчийн эрхтэйгээр өөрийн академийн платформоор дамжуулан суралцах боломжийг нээж нийт ажилтнуудаа амжилттай хамрууллаа.

Ажилтнуудынхаа тогтвортой санхүүжилтийн бодлого журмын мэдлэгийг тогтмол дээшлүүлэх, ерөнхий болон мэргэжлийн мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэх зорилготойгоор академийн платформ болон танхимын сургалтуудаар дамжуулан ажилтнуудаа чадавхжууллаа.



Нийгмийн үзүүлэлтүүд

График 1: Ажилтнуудын сургалтанд хамрагдсан байдал

Тогтвортой санхүүжилт	4074 Хүн/цаг		1876		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ	181 Хүн/цаг		181		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Ногоон санхүүжилт	4010 Хүн/цаг		1862		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Бодлого, журмын тухай сургалт	181 Хүн/цаг		181		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
ХАБЭА-ын сургалт	444 Хүн/цаг		444		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Амилуулах суурь тусламжийн сургалт	248 Хүн/цаг		62		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Гамшиг ослоос хамгаалах сургалт	117 Хүн/цаг		39		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Галын аюулгүй ажиллагааны сургалт	147 Хүн/цаг		49		Сургалтад хамрагдсан ажилтны тоо
Физик эрсдэлийг бууруулахтай холбоотой бусад сургалт	461 Хүн/цаг		461		Сургалтад хамрагдсан ажилтны тоо

АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ХӨНГӨЛӨЛТ, ХАНГАМЖ:

Голомт банк ажилтны бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж олон төрлийн хөнгөлөлт хангамжийг олгодог билээ.

Эдгээрээс дурдвал:

-Ажилтнуудыг уян хатан ажлын цаг зайнаас ажиллах нөхцөлөөр хангасан төдийгүй

-Ажилтны өөрийн болон хүүхдийн төрсөн өдрийн цалинтай чөлөө,

-Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр,

-Жирэмсэн ээжүүдийн ажлын цагийг богиносгох

зэрэг боломжийг улам сайжруулж ажиллалаа.

Банкандаа тасралтгүй 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудад зориулсан "Лоял ажилтан" хөтөлбөрийг 2 дахь жилдээ ажилттай хэрэгжүүлж нийт 400 орчим ажилтнуудыг хамруулсан үйл ажиллагааг зохион байгууллаа.

Нийт ажилтнууддаа өдөр бүр эмчийн үзлэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ 1300 орчим ажилтныг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрууллаа.

Жирэмсний амралттай,

хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудынхаа тасралтгүй сурч хөгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилготой "G Mommy's" арга хэмжээг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж 70 орчим ажилтан оролцлоо.

Ажилтнуудынхаа гэр бүл, хүүхдүүдийнх нь боловсролыг дэмжих, сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд нь чиглэсэн "Good vibes" хөтөлбөрийг 5 дахь жилдээ 60 гаруй хүүхдийг хамруулан амжилттай хэрэгжүүллээ.



Нийгмийн үзүүлэлтүүд

НИЙГМИЙН САЙН САЙХАНД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР:



Бид эх дэлхийгээ хайрлаж, ногоон ирээдүйг бүтээхийн төлөө Улаанбаатар хотын цор ганц гацууран төгөл болох “Голомтын төгөл”-ийг бүтээхээр Үндэсний соёл амралтын хүрээлэнд 3 дахь жилдээ гацуур мод тарилаа. 2022 онд шинээр 140 гацуур мод тарьж, “Голомтын төгөл” маань нийт 650 орчим модтой боллоо.

Монгол орон даяар хэрэгжих, ЕБС-ийн 400.000 сурагчийн англи хэлний мэдлэг, практик хэрэглээг сайжруулах, мөн англи хэлний нийт 3100 багшийг чадавхжуулах төслийг хэрэгжүүлэхэд Боловсролын яам, Гүрэн академитай хамтран ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх 17 дахь зорилгын хүрээнд

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн Хүний нөөцийн ажилтнуудад зориулан “SME mentorship” хөтөлбөрийг зохион байгуулж 30 орчим жижиг, дунд бизнес эрхлэгч байгууллагын 30 гаруй Хүний нөөцийн ажилтнуудыг хамруулж мэдлэг туршлагаасаа хуваалцан чадавхжуулахад хувь нэмрээ оруулан ажиллалаа.

Сайн сайхныг санхүүжүүлэгч Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд Европын холбооны санхүүжилтээр “Дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” төслийг Монгол улсад анх удаа Боловсролын яам, Отгонтэнгэр их сургууль, СЭЗИС-тай хамтран



хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Европын холбооны хамтрагч талууд болох ХБНГУ, Франц, Грек, Румын улсын тэргүүн туршлагаас суралцаж Монгол Улсын банк санхүүгийн салбар болон дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтын

хөтөлбөрийг нутагшуулахаар зорьж байгаа төдийгүй одоогоор 26 оюутан Голомт банканд ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдаж байна. Голомт банк оюутан залууст зориулсан бизнесийн бодит төслүүд дээр ажиллаж өөрийгөө сорих, мэдлэг

туршлага олж авах хөгжлийн цогц сургалтуудад хамрагдах, өөрийгөө сорихын зэрэгцээ цалин авах боломжийг олгодгоороо онцлогтой “Судлаач оюутан хөтөлбөр”-ийг 10 дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ.

ГОЛОМТ БАНК
Одоо өөрийн эрхшээлээр

Erasmus+ MONGWBL

*Ажлаа зөв сонгохоос
Амжилт эхэлдэг*

**Европын холбооны санхүүжилттэй Эрасмус+
“Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
зорилгоор монголын дээд боловсролын тогтолцоонд
ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэх” MONGWBL
төсөлд хамрагдахыг урьж байна.**

Нийгмийн үзүүлэлтүүд

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ИЛ
ТОД БАЙДАЛ

“Өв соёлын голомт” төсөл

Голомт банк “Өв соёлын голомт” түүх археологийн төслийг санаачилж, ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж эхэллээ. Төслийн эхний ажил болох Хэрэйдийн Ван ханы ордон буюу Түргэний балгас-Туулын “Хар Түнэ Орд” дурсгалт газарт археологийн малтлага, судалгааны ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Энэхүү түүхийн дурсгалт газарт 2006 оноос хойш судалгаа шинжилгээний ямар нэгэн ажил хийгдээгүй

урт хугацаанд зогсонги байдалтай байсан ч сэргээн судлахаар болсон түүхийн 2-3 цаг үеийг хамаарах өндөр ач холбогдол бүхий дурсгалт газар юм. Археологийн хүрээлэн урьд өмнө санхүүжилтээс шалтгаалан малтлага, судалгааны ажлыг дийлэнхдээ гадны байгууллагуудтай хамтран хийдэг байсан бол Голомт банк энэ салбарт хөрөнгө оруулалт хийсэн анхны дотоодын хувийн хэвшлийн байгууллага болсноороо

онцлогтой. Тус хамтын ажиллагаа нь зөвхөн энэ төслөөр хязгаарлагдахгүй бөгөөд цаашид Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг арга зүйн дагуу шинжилж, гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүд дээр хамтарч, урт хугацаанд дэмжин ажиллана.





“Зүрх мартахгүй” төсөл

ТХ-ийн Эрүүл мэндийг дэмжих зорилгын хүрээнд Голомт банкны дэргэдэх “Алтантүлхүүр” хүүхдийн сан “Зүрх мартахгүй” төслийг 3 дахь жилдээ дэмжин ажиллалаа. Төслийн багийнхан 2022 онд Монгол, Киргизстан, Тува гурван улсын олон мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулан, мэс засал хийж амьдрал бэлэглэсэн. Голомт банкны зүгээс тус төсөлд жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна шаардлагатай бусад

зүйлсээр дэмжин ажиллаж байна. Бидний хамтын ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар нийт 18 мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулж, 600 гаруй хүүхдэд мэс заслыг амжилттай хийгээд байна. Эх орныхоо өнцөг булан бүрд очиж төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдэд дэлхийн жишиг үнээс 5-10 дахин бага зардлаар 99 хувийн үр дүнтэй мэс засал хийдэг энэхүү төслийг НҮБ-аас эхлэн олон улсад сонирхон анхаарлаа

хандуулж эхэлсэн. Эдгээрээс гадна Англи, АНУ, Бельги зэрэг орнуудаас зүрхний төрөлхийн гажигтай хүүхдүүд ирж мэс засалд амжилттай орсон тохиолдлууд ч бий. Төслийн багийнхан анх жилд 44 хүүхдэд мэс засал хийх төлөвлөгөөтэй байсан ч хамтын ажиллагааны үр дүнд санхүүгийн болон бусад асуудлууд тодорхой хэмжээнд шийдэгдсэнээр нэг жилд хийх мэс заслын тоог 350-360 болгон нэмэгдүүллээ.





Нийгмийн үзүүлэлтүүд

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Боловсролыг дэмжигч Голомт банк нийгмийн хариуцлагын болон ТХ-ийн чанартай боловсролыг дэмжих IV зорилгын хүрээнд жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг “100 оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-өө 18 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2022 оны байдлаар энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нийт 50 гаруй их, дээд сургуулийн 15 салбарын нийт 1,600 оюутанд 1 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулаад байна.

Голомт банкны нэрэмжит тэтгэлэгт оюутан болсноор зөвхөн мөнгөн тэтгэлэг аваад зогсохгүй банкны судлаач оюутнаар ажиллах, мөн “G student club”-ийн гишүүн болж сурч хөгжих, нийгэмдээ чиглэсэн ажлууд хийх зэрэг хувь хүнийхээ хувьд өөрийгөө хөгжүүлэх, сорих боломжууд нээгддэг бөгөөд тэтгэлгийг мэргэжил харгалзахгүй олгодгоороо давуу талтай. Тус хөтөлбөрт хамрагдсан оюутнууд их дээд сургуулиа төгсөөд Голомт банканд ажиллах тогтвортой

ажлын байраар хангагдах боломжтой төдийгүй ажлын гараагаа банкнаас эхэлж, удирдах албан тушаалд амжилттай ажиллаж байгаа олон жишээ бий. Тэтгэлэгт оюутнууд Голомт банкны судлаач оюутнаар ажиллах боломж давхар нээгддэг иймд оюутнууд онолын түвшинд олж авсан мэдлэгээ практик дээр хэрэгжүүлэн мэргэжлийн хамт олон дунд судалгааны ажил хийж өөрийгөө хөгжүүлэх бүрэн боломжтой.



Морин хуурын чуулга

Голомт банк үндэсний язгуур урлаг, түүх соёлыг дэлхий дахинд таниулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад хувь нэмрээ оруулан Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны

түнш байгууллагаар 12 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Морин хуурын чуулга нь 2022 онд 30 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд хоёр байгууллагын хамтын ажиллагааны

хугацаанд гадаад болон дотооддоо үндэсний урлагийг сурталчлан таниулж нийт 35 гаруй томоохон тоглолт хийсэн.





Нийгмийн үзүүлэлтүүд

ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ УДИРДЛАГА

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Голомт банк нь дотоод худалдан авалтдаа анхаарч тогтвортой

ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлагыг хэрэгжүүлж байна. Энэхүү хүрээнд дотоодын тогтвортой

харилцагчдаа дэмжин ажиллаж, нийт ханган нийлүүлэлтийнхээ 80 хувийг дотоодоосоо хангаж байна.

463 дуудлагаар

1378

ширхэг гэрлийг засварлан лед гэрлээр сольсноор 3.5 хувийн эрчим хүчний хэмнэлтийг үзүүлсэн байна.



Засаглалын үзүүлэлтүүд



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Голомт банкны засаглалын тогтолцоо



АВЛИГА, ЁС ЗҮЙ

Голомт банк нь авлигын эсрэг бодлогыг баримталж, бизнесийн харилцаандаа ёс зүйн өндөр хэм, хэмжээг баримталдаг. Авлига, хээл хахууль өгөх, хүлээн авах, шууд болон шууд бус хэлбэрээр авлига, хээл хахууль санал болгох, амлах, түүнчлэн давуу тал эдлүүлэх, эдлэхийг шаардах, түүнд оролцохыг удирдлагын баг

болон нийт ажилтнуудад хориглож, авлигын эсрэг бодлого, журмаараа зохицуулан ажиллаж байна. Голомт банкны нийт ажилтнууд авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн болон бусад төрлийн дарамт зэрэг Банкны дотоод бодлого,

журам, ёс зүйн код зөрчсөн аливаа зүй бус үйлдлийг шүгэл үлээх журмын дагуу мэдээлэх эрх, үүрэгтэй. Банк нь холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд мэдээлэгчийн хувийн мэдээллийг чандлан нууцалж, тухайн зөрчилд хууль дүрэм, журмын дагуу арга хэмжээ авч байна.

КОМПЛАЕНС /ХУУЛЬ ДҮРМИЙН МӨРДӨЛТ

Комплаенсийн бодлого

Комплаенсийн хэлтэс нь банкны Ерөнхийлөгчийн шууд удирдлага дор ажилладаг ба банкны ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын багт ажлаа тайлагнадаг. Комплаенсийн хэлтсийн чиг үүрэгт ерөнхий комплаенсийн холбогдох асуудлууд болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа ордог. Комплаенсийн хэлтэс нь бүтцийн хувьд банкны ерөнхийлөгчид харьяалагддаг бие даасан тусдаа нэгж юм. Хэлтсийн захирал банкны Гүйцэтгэх

удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д шууд тайлагнадаг.

Банк нь Комплаенсийн бодлоготой ба энэхүү бодлогоо ТУЗ-өөр батлуулж жил бүр хянан нийцүүлдэг. Хамгийн сүүлд 2022 оны 6-р сард хянан нийцүүлэлтийг хийж холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулан ТУЗ-өөр батлуулсан. Комплаенсийн бодлого нь дараах асуудлыг хамардаг. Үүнд: Бодлого журмын зохицуулалт; Комплаенсийн эрсдэлийн

удирдлага; Харилцагч таньж мэдэх; Гүйлгээний хяналт; Хориг арга хэмжээний хэрэгжилт; Сургалт хөгжлийн хөтөлбөр (шинэ ажилтнуудад зориулсан анхан шатны сургалт, харилцагчтай нүүр тулж үйлчилдэг ажилтнуудад зориулсан гүнзгийрүүлсэн сургалт, тусгайлсан сургалт, удирдлагуудад зориулсан сургалт гэх мэт); Хараат бус хяналт шалгалт; Мэдээлэх үүргийн хэрэгжилт; Мэдээлэл хадгалах гэх мэт 2022 онд банк нь Комплаенсийн бодлого,

Компанийн засаглал

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам болон бусад баримт бичгийг олон улсын стандарт, шаардлага, дотоодын хууль, тогтоомжийн өөрчлөлтүүдтэй нийцүүлэн шинэчлэн батлуулсан.

2022 оны хувьд маш онцлог буюу сорилт ихтэй жил байсан. Учир нь олон улсын геополитикийн нөхцөл байдлаас хамаарч банкны Компаенсийн үйл ажиллагааг тэр дундаа гадаад төлбөр тооцоог өндөр хяналттай гүйцэтгэх шаардлага үүссэн юм. Иймд

Голомт банк Компаенсийн бодлогоо чангатгаж олон улсын хориг арга хэмжээний хэрэгжилтийг өндөр түвшинд мөрдөж ажилласан. Голомт банк нь өөрийн корреспондент харилцаатай банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч, түншүүдийнхээ дотоод бодлогыг зөрчихгүй байхын зэрэгцээ харилцагчдынхаа төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх үүргийнхээ хүрээнд тухайн хориг арга хэмжээний агуулга, хамрах хүрээ, төрөл зэргийг нарийн судалж аливаа хоригийг

зөрчихгүй байх арга хэмжээг авч ажилладаг.

Банкны ажилтнуудын Компаенсийн талаарх мэдлэг, мэдээллийг тогтмол шинэчилж, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой зөвлөмж, зааврыг тогтмол өгч ажилласан. Түүнчлэн банкны гүйцэтгэх удирдлагуудын түвшинд бизнесийн зөв шийдвэр гаргалтад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хориг арга хэмжээтэй холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргүүлсэн.

Компанийн засаглал

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

ТоС-ын хүрээнд Голомт банкны нэгдсэн олон улсын санаачилга, хамтын амлалт

НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд



Парисын хэлэлцээр



Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт



Хариуцлагатай банкны зарчмууд

**"Хариуцлагатай банкны зарчим"-д
НЭГДСЭН 3 ЖИЛ**

 Нийцэл

 Нөлөөлөл зориулалт түвшин

 Хариуцагч, үйлчлүүлэгчид

 Хамтран өжиллэгчид, Хуульчид зөвлөхчид

 Засаглал, соёл

 Үйл тэд соёлод, хариуцагчид

PCAF



Салбарын нэмэлт үзүүлэлтүүд





Салбарын нэмэлт үзүүлэлтүүд

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Ногоон зээл

Голомт Банк нь Санхүүгийн Тогтвортой Байдлын зөвлөлийн хуралдаанаар Монгол Банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Хадгаламжийн даатгалын корпорациас хамтран гаргасан МУ-

ын Ногоон Таксономийн дагуу байгаль, орчин нийгэмд ээлтэй ногоон үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлттэй уялдуулан банкны ногоон зээлийн багцын хэмжээг улирал бүр Монгол Банканд

тайлагнадаг билээ. Тайлант хугацаанд Голомт Банкны өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн ногоон зориулалт бүхий ногоон зээлийн багцын хэмжээг доорх хүснэгтээс харна уу:

Ногоон зээлийн багцын үлдэгдэл (сая.төг): 95,852.00



НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Амины орон сууцны ногоон зээл

2022 онд “Амины орон сууцны ногоон зээл”-ийн тушаалыг батлуулсан нь Монгол Улсад анх удаа олон улсын EDGE-н шаардлагуудыг хангасан бүтээгдэхүүн болсноороо онцлог. Энэхүү бүтээгдэхүүн нь Монголын Таксономийн шаардлагыг хангасан, эрчим хүчний хэмнэлттэй АОС худалдан авах, АОС барьж дуусгах зээл авах хүсэлтэй харилцагчдыг санхүүжүүлэх зориулалттай юм. Монголд улсад хэрэгжиж буй амины орон сууцны төслүүд энгийн АОС-ны шаардлагыг хангахаас гадна “В”-ээс дээш ангиллын эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ, мөн олон улсын EDGE сертификаттайгаар

Голомт банктай дээрх зээлийн бүтээгдэхүүнээр хамтран ажиллах гэрээ байгуулах боломжтой. Энэхүү зээлийн хүү нь Монгол Банкны Бодлогын хүүтэй уялдсан ба EDGE сертификатын зэрэглэлээс хамаарч Бодлогын Хүү +4% болон Бодлогын Хүү +2% буюу одоогийн байдлаар 14-16%-ийн хүүтэй ерөнхий нөхцөлөөс бага хүүтэй зээлээр АОС-тай болох боломжийг олгож байна. Бүтээгдэхүүний нөхцөлд давхар МИК-ийн шаардлага хангуулахаар тусгасан тул МИК-д худалдах боломжтой. Олон улсын EDGE сертификаттай төсөл болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран

ажиллах нь Монгол улсад олон улсын стандартыг хангасан, хүний биед сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, иргэдийн зардлыг хэмнэх гэх мэт олон давуу талтай бөгөөд барилгын салбарт ажиллаж буй байгууллагуудад шинэ чиглэл, санаачилга өгөх юм. Харилцагчид сонирхсон ногоон сууцаа энгийн АОС-ны зээлийн бүтээгдэхүүнээр судлуулан авах боломжтой ч, энэхүү шинэ бүтээгдэхүүн нь илүү найдвартай, бага хүүтэйгээрээ давуу талтай ба харилцагчид нэмэлт сонголт санал болгох, банканд ногоон зээлийг дэмжих боломжийг олгож байна.



Салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Автомашины ногоон зээл

Голомт банк нь 2021 оны 12 сарын 20-ны өдрөөс эхлэн цахилгаан болон эко автомашины зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн бөгөөд 2022 оны 11 сарын 27-н өдрийн байдлаар 62 харилцагчид 2.2 тэрбум төгрөгийн багцыг бүрдүүлээд байна. Цахилгаан автомашин нь байгаль орчинд хэрхэн эерэг нөлөө

үзүүлдэг талаар, харилцагчид санхүүгийн бодит хэмнэлт хийх боломж зэрэг мэдээлийг харилцагчдадаа түгээх үүднээс идэвхжүүлэлтийн олон арга хэрэгслийг хэрэгжүүлж байна. Үүнд: Нийт боломжит 3000 харилцагчид масс мессеж илгээж зээлийн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй

мэдээлэл хүргүүлсэн мөн МСМ ХХК-тай хамтран цахилгаан автомашины бусад автомашинаас ялгарах давуу тал болон дэлхийд автомашин хэрэглэгчийн чиг хандлагаа хаашаа чиглэж байгаа зэрэг мэдээллүүдийг хүргүүлсэн зэрэг олон ажлуудыг хийсээр байна.



Тогтвортой, Ногоон бизнесийн зээл

2021 онд Банкныхаа ТоС-ын стратегийн хүрээнд “Тогтвортой, Ногоон бизнесийн зээл” –ийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэн Бизнесийн үйл ажиллагаандаа Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын хувьд тогтвортой байдлыг нэвтрүүлэх, Байгаль орчинд ээлтэй байхыг зорьж буй Бизнес эрхлэгч Иргэн, ААН-үүдэд санал болгон ажилласаар байна. Голомт банкны хувьд нийгмийн хариуцлага, ОУ-н томоохон санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан гадны хямд өртөгтэй эх үүсвэрээр хязгаарлагдалгүй тодорхой шалгуур хангасан

Бизнес эрхлэгч Иргэн, ААН-үүдэд өөрийн эх үүсвэрээр ашгийг хойш тавьж хамгийн бага хүүтэйгээр, хамгийн урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүнийг бизнесийнх нь бүхий л төрлийн хэрэгцээнд нь / эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын чиглэлээр/ нийцүүлэн санал болгон үйлчилж байна. Тодруулбал, Харилцагч аль хэдий нь өөрийн хөрөнгөөр Ногоон технологи гаднаас импортлон үйл ажиллагаандаа нэвтрүүлчихсэн эсвэл Байгаль орчинд ээлтэй технологийг банкнаас хүссэн санхүүжилтээрээ авахаар зорьж буй бол энэхүү шийдвэрийг нь

хүндэтгэн хүлээн авч тухайн бизнес эрхлэгчийг аль болох дэмжиж ажиллах чиглэлд шийдвэрээ бусад энгийн харилцагчдаас илүү уян хатан гарган ажилладаг болно.

Бүтээгдэхүүний голлох нөхцөлийн талаар товч дурдвал 1,0 тэрбум ₮ хүртэл дүнтэй зээлийг 84 сарын хугацаатайгаар олгохын зэрэгцээ 2 хүртэл жилийн хугацаатай үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх буюу харилцагч өөрийнхөө бизнесийн онцлогт тохируулан эргэн төлөлтийн графикаа уян хатан зохиох боломжтойгоороо онцлогтой юм.



Салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Тогтвортой хөгжлийн тоон мэдээллүүд

Дижитал банк		
	2022	Хэмжих нэгж
Дижитал сувгийн/ Интернэт банк смарт/ нийт хэрэглэгчийн тоо	714,329	тоо
СошиалПэй хэрэглэгчдийн тоо	336,740	тоо
Дижитал сувгийн идэвхтэй хэрэглэгчийн тоо	328,887	тоо
Дижитал сувгийн гүйлгээний тоо	53,078,617	тоо
Нийт CDM (ATM with Smart functionality)	411	тоо
Интернэт банкны идэвхтэй хэрэглэгчийн өсөлтийн хувь (2021 онтой харьцуулсан байдлаар)	127	хувь
Смарт банкны идэвхтэй хэрэглэгчийн тоо (2021 онтой харьцуулсан байдлаар)	131	хувь
Дижитал сувгийн үйлчилгээний тоо	845,738	тоо
Дижитал сувгийн үйлчилгээний тооны өсөлтийн хувь/2021 онтой харьцуулахад/	152	хувь

Харилцагчдийн гомдол саналыг шийдвэрлэсэн байдал		
	2022	Хэмжих
Нийт гарсан гомдлын тоо	27,403	Тоо
Шийдвэрлэсэн гомдлын тоо хувь	100%	Тоо
5 хоногийн дотор шийдвэрлэсэн гомдлын хувь	93,9%	Тоо



Салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Банкны ажилтнуудын хүйсийн харьцаа		
	2022	Хэмжих нэгж
Ажилчдын тоо /Нийт/	2406	
Эмэгтэй	1662	Ажилтны тоо
Эрэгтэй	744	Ажилтны тоо
Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан	22	Ажилтны тоо
Нэг буюу түүнээс дээш жил ажиллаж буй ажилтан	1569	Ажилтны тоо
Зээлийн болон фронт оффисын ажилтнуудын тоо	1201	
Эмэгтэй	388	Ажилтны тоо
Эрэгтэй	813	Ажилтны тоо
Газрын захирлууд	18	
Эмэгтэй	5	Ажилтны тоо
Эрэгтэй	13	Ажилтны тоо
Хэлтсийн захирлууд, Салбарын захирлууд	143	
Эмэгтэй	66	Ажилтны тоо
Эрэгтэй	77	Ажилтны тоо

Салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Ажилтнуудад зориулсан сургалтын тоо	Хүн цаг	Тоо
Тогтвортой санхүүжилт	4074	1876
Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ	181	181
Ногоон санхүүжилт	4010	1862
Бодлого, журмын тухай сургалт	181	181
Сертификаттай сургалт	256	18

Ажилтнуудад зориулсан тэтгэмж, хөнгөлөлт	Хүн цаг	Тоо
Хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж	619	Ажилтны тоо
Даавууны хоног авсан ажилтны тоо	61	Ажилтны тоо
Тэтгэвэрт гарсан ажилтны тоо	8	Ажилтны тоо
Вакцинд хамрагдсан ажилчдын тоо/ковид/	1144	Ажилтны тоо
Вакцинд хамрагдсан ажилчдын тоо	107	Ажилтны тоо
Цус хандивлах аян	99	Ажилтны тоо
Мод тарих аян	140	Ажилтны тоо

Салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Бусад	Хүн цаг	Тоо
Ажилд авсан төгсөгчдийн тоо	282	Ажилтны тоо
Дадлагын оюутан	35	Ажилтны тоо
Ажилчдын эргэц	18.66	Хувь
Ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа- GPTW	84	Хувь
Төрсөн эхчүүдийн ажлын байр хадгалалтын хувь	100	Хувь
Вакцинд хамрагдсан ажилчдын тоо	107	Ажилтны тоо

Банкны дотоод хэрэглээ Хүлэмжийн хийн ялгарал	2022	Хэмжих нэгж
Нийт эрчим хүчний хэрэглээ	1,379,706.00	Квт
Нийт дахивар хог хаягдлын хэмжээ		
Цаас	103.70	Киллограмм
Хуванцар	221.90	Киллограмм
Шил	1085.00	Ширхэг
Уут	221.90	Киллограмм
Лааз	35.10	Киллограмм
Дахин боловсруулах бусад шил	308.90	Киллограмм
Нийт усны хэрэглээ	7,349.00	м3
Нийт CO2 (Scope1)	31.90	Киллограмм
Нийт CO2 (Scope2)	5,475.96	тн



www.golomtbank.com